

УИХ-ын гишүүн нь тухайлсан асуудлаар санал дүгнэлт боловсруулах ажлын хэсэгт орж ажилладаг.

№	Огноо	Ажлын хэсэг байгуулах захирамж, тогтоол гаргасан байгууллага, албан тушаалтан	Ажлын хэсгийн үүрэг
1	2012.12.13	Монгол Улсын Их Хурал дахь Ардчилсан Намын бүлгийн хуралдааны шийдвэр, Дугаар 07	Оюутолгойн орд газарт шинээр их хэмжээний зэс болон алтны нөөц илэрсэн ба энэ нөөцтэй Entree Gold гэх компани холбоотой эсэх, холбоотой бол Монгол Улсын хууль, тогтоомж, энэ ордыг ашиглахтай холбогдуулж байгуулсан гэрээ, хэлэлцээртэй нийцэж байгаа эсэх, мөн энэ асуудалтай холбогдуулан цаашид авах арга хэмжээ болон Тавантолгойн орд газрын хайгуулын тусгай зөвшөөрлийг ашиглалтын тусгай зөвшөөрөлд шилжүүлсэн болон уг ордоос Ухаа худгийн ордыг тусгаарласан үйл ажиллагаа нь холбогдох хууль, тогтоомжид нийцсэн эсэх талаарх маргааныг судалж, санал дүгнэлт боловсруулах чиг үүрэг бүхий
2	2013.02.08	Монгол Улсын Их Хурлын Даргын Захирамж, Дугаар 27	Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлыг судлах үүрэг бүхий
3	2013.04.12	Монгол Улсын Их Хурлын Байнгын Хорооны Тогтоол, Дугаар 03 Эдийн Засгийн Байнгын Хороо	Үнэт цаасны зах зээлийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий
4	2013.04.22	Монгол Улсын Их Хурлын Даргын Захирамж, Дугаар 73	Улс орнуудын эдийн засгийн байдал манай улсын эдийн засагт үзүүлэх нөлөө, үр дагавар, түүнийг даван туулах арга зам, гадаадын хөрөнгө оруулалтын нөхцөл байдлыг судалж, дүгнэлт гаргах үүрэг бүхий
5	2013.09.11	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Захирамж Дугаар 08	Орон нутгийн хөгжлийн сангийн үйл явцад иргэдийн оролцоог хангаж буй байдалд үнэлгээ хийн, иргэдийн оролцоог хязгаарлаж буй хууль, тогтоомж, журам дүрмийг өөрчлөх, шинэчлэх, хүчингүй болгох зорилготой үзэл баримтлал боловсруулах үүрэг бүхий
6	2013.09.17	Монгол Улсын Их Хурлын Байнгын Хорооны Тогтоол, Дугаар 13 Эдийн Засгийн Байнгын Хороо	Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын ээлжит бус чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, Байнгын хорооны санал дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий